БАТЛАВ
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ О.МӨНХБАЯР

2023 оны .... дугаар сарын ....-ны өдөр

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН “2021-2024 ОНЫ АЛБА ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 05 дугаар сарын 03 Мандалговь хот

| № | Тэргүүлэх чиглэл | Хэрэгжүүлэх ажил | Хариуцах албан тушаалтан | Хугацаа | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх. | 1.1. Хэлтсийн алба хаагчдын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах зорилгоор 2024 оны төсөвт лабораторийн барилга барих асуудлыг уламжлан шийдвэрлүүлэх. | Хэлтсийн дарга, нягтлан бодогч | Жилдээ | Лабораторийн зориулалтын байр барих зардлыг 2024 оны төсөвт тусгуулахад холбогдох материалыг хүргүүлсэн байна. |
| 2. | | 1.2.Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх. | Хэлтсийн дарга | Жилдээ | Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. |
| 3. | | 1.3.Төрийн албан хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдах. | Албан хаагчид | Жилдээ | Алба хаагчийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд аливаа нөлөөллөөс ангид байх нөхцөлийг ханган, эрх зүйн талаарх сургалтад хамрагдсан байна. |
| 4. | | 1.4.Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн | Албан хаагчид | Жилдээ | Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэл, заналхийлэл, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас өөрийгөө |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гишүүнийг хамгаалах талаар урьдчилан сэргийлэх ажил зохиох, тодорхой арга хэмжээ авах. | | | болон гэр бүлээ хамгаалах талаар алба хаагчдад эрх зүйн зөвлөгөө өгөх, сургалтад хамрагдсан байна. |
| 5. | | 1.5.Шинжээч, мэргэжилтний мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд зориулсан номын сантай болж, тохижуулах. | Албан хаагчид | Жилдээ | Хэлтэс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шинжээч, мэргэжилтний мэдлэг, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх ном, сэтгүүл, эмхэтгэл, гарын авлага бүхий номын сантай болсон байна. |
| 6. | | 1.6.Шинжилгээний орчин үеийн техник, технологи нэвтрүүлж алба хаагчдад шинэ арга барил, ур чадварыг эзэмшүүлэх. | Албан хаагчид | Жилдээ | Орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шинжээч нарыг арга барил, ур чадварыг эзэмшүүлэх тал дээр сургалт зохион байгуулах. |
| 7. | | 1.7.Алба хаагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх санаачилгад дэмжлэг үзүүлэх. | Албан хаагчид | Жилдээ | Алба хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, судалгаа, шинжилгээний ажлыг хийх санаачлагыг дэмжих тодорхой ажил зохионо. |
| 8. | 2.Алба хаагчийн эрүүл мэндийг хамгаалах. | 2.1.“Эрүүл аж төрөх ёс” сэдвийн хүрээнд алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулах. | а/ч Ц.Цэвэлмаа | 4-р улиралд | Алба хаагчдад эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилсэн байна. |
| 9. | | 2.2.Алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах нөхцөл боломжоор хангах. | а/х М.Баттүвшин | Жилдээ | Алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин эмгэгийг эрт үед илрүүлэх үзлэгийн багц үйлчилгээнд хамрагдсан байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10. | | 2.3.Алба хаагчдын эрүүл мэндийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах. | Албан хаагчид | Жилдээ | Алба хаагчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгрүүлэх спортын уралдаан тэмцээн болон бусад арга хэмжээ зохион байгуулсан байна. |
| 11. | 3.Алба хаагчийн цалин урамшууллыг нэмэгдүүлэх. | 3.1.Алба хаагчид туслах аж ахуй эрхлэх, мал, гэрийн тэжээвэр амьтан өсгөх, хүнсний ногоо тариалах зэргээр амьдрал ахуйгаа дээшлүүлэх санаачилгыг дэмжиж ажиллах. | Хэлтсийн дарга | Жилдээ | Тус хэлтсийн алба хаагчдын амьдрал, ахуй дээшилнэ. |
| 12. | | 3.2.Алба хаагч, ажилтнуудыг банк болон санхүүгийн байгууллагаас зээл /цалин, орон сууц, өрхийн гэх мэт/ авахад дэмжлэг үзүүлэх. | Хэлтсийн дарга | Жилдээ | |
| 13. | | 3.3.Алба хаагч хувийн орон сууцны болон зуслангийн газартай болоход байгууллагын зүгээс санаачилга гарган дэмжиж ажиллах. | Хэлтсийн дарга | Жилдээ | |
| 14. | | 3.4.Харилцагч банктай зөвлөлдөж алба хаагчдад бага хүүтэй нөхцөлөөр зээл олгуулах асуудалд санаачилгатай ажиллах. | Хэлтсийн дарга | Жилдээ | |
| 15. | | 3.5.Алба хаагчид өөрийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлаж банкаа сонгож цалингаа авах нөхцөл боломжийг бүрдүүлэх. | Хэлтсийн дарга | Жилдээ | |
| 16. | 4.Байгууллагын ажлын онцлог, албаны нэр хүндийг | 4.1.Апба хаагчдын гэр бүлийг хүлээн авч байгууллагын зорилго, зорилт, чиг үүрэг болон ололт, амжилт, дутагдлыг таниулж, тэдний дэмжлэг туслалцаа чухал болох талаар уулзалт, ярилцлага зохион байгуулах. | а/х Э.Баярсүрэн | Жилдээ | Шүүх шинжилгээний байгууллагын ажлын онцлог, үйл ажиллагааг ар гэрийнхэнд нь ойлгуулж, албаны үйл ажиллагааг танилцуулж, сурталчилснаар гэр бүлийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17. | сурталчлах | 4.2.Алба хаагчдын гэр бүлд баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлын үед мэндчилгээ, талархал илгээх. | а/х Э.Баярсүрэн | Жилдээ | гишүүдэд эерэг хандлага төлөвшинө. |
| 18. | | 4.3.Алба хаагчийн амьдралд гачигдал зовлон тохиолдсон үед дэмжлэг туслалцаа үзүүлэх. | Албан хаагчид | Жилдээ | |
| 19. | | 4.4.Алба хаагчдын хүүхдүүдийн судалгааг гаргаж, баяр ёслолын үед бэлэг, дурсгалын зүйл гардуулах. | а/х Э.Шинэцэцэг | Жилдээ | Алба хаагч хамт олноороо бахархах, харилцаа хандлагад эерэг нөлөө үзүүлнэ. |
| 20. | 5.Хэлтсээс тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудад үзүүлэх халамжийг нэмэгдүүлэх, “Ахмадуудын ажил-амьдралын баялаг” туршлагаас залуу үеийнхэнд эзэмшүүлэх, тэдний харилцаа, холбоог бэхжүүлэх. | 5.1.Ахмад ажилтнуудад байгууллагын зүгээс зохих журмын дагуу тусламж, дэмжлэг, тэтгэмж үзүүлэх. | а/х Э.Шинэцэцэг | Жилдээ | Хэлтсийн зүгээс ахмад ажилтнуудад дэмжлэг, туслалцаа үзүүлсэн байна. |
| 21. | | 5.2.Ахмад ажилтнууд залуу үеийг халамжлах, сургах, туршлага дадлага эзэмшүүлэх, байгууллагын түүхэн уламжлалыг сурталчлах ажилд нь ахмадын зөвлөлд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах. | Хэлтсийн дарга, нягтлан бодогч нар | Жилдээ | “Дурсамж, сургамж, зөвлөмж” арга хэмжээ зохион байгуулж ахмадын түүхэн уламжлалыг сурталчилж ажилласан байна. |

БОЛОВСРУУЛСАН: ГАРЫН ХЭЭНИЙ САНЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ АХЛАГЧ С.ХҮРЭЛТОГОО